

17

ЧИНГИС ХААН МААНЬ ХЭДЭН САРЫН ХЭДЭНД ТӨРСӨН БОЛОО.....?

Л.Дамбадорж

Их эзэн хааны маань унасан газар Дэлүүнболдог, угаасан ус нь Хан хэнтийн рашаан булаг гэдгийг хэн бүхэн сонсож дуулсан, уншиж мэдсэн байдаг билээ. Хувь хүмүүний зан төрх, амьдралын замнал, авъяас билэг, эрдэм ухаан, аз хийморь, хань нөхөд, хөдөлмөр бүтээл зэрэг ерөнхий байдлыг нь шинжсэний дагуу тэр хүмүүн ямар өдөр, гараг, сар, ямар ордоны нөлөөнд төрсөнийг нь тодорхойлж болдог гэлцдэг. Ингээд эзэн Чингис хааныхаа төрсөн сар, өдөр, гараг, цагийг тодорхойлохыг оролдсу.

Монгол он тоололын өнөө үед мөрдөж буй цаг тооны бичигээс үндэслэн “**Жаран жараны цаг тооны бичиг**”-(1207-гоос 4626 он дуусталх 3600 жил)-ийг жил нэг бүрийн ёгт нэр, суудал, мэнгэ ба жил бүрийн 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31-ний өдөрийг дуусталх бүх өдөрийн гараг, өдөрийн жил, түүний өнгө, өдөрийн мэнгэ ба суудал зэрэгийг би-вээр оноон бүрдүүлж 128 хүрдээр тооцоолон гаргасан билээ. Зурхайч мэргэдийн туурвисан ном зохиолд өгүүлсэн зурхайн зурлагын бичлэгтэй тэрхүү хүрднүүд дэх он, жил, сар, өдөр гэхчлэнтэй дүйцүүлж хөөсөөр ийнхүү их хааныхаа төрсөн өдөрийн гараг, жил, мэнгэ, суудал мэтийг оноон тогтоохыг зорьсон болой.

“**Монголын нэвтэрхий толь**”-д Чингис хаан 1162 онд төрөөд 1227 онд тэнгэртээ хальсан, “**Encyclopedia Britanica**”-д Jenghiz khan 1162 онд мэндлээд 1227 онд насан өөд болсон гэсэн байдаг. Харин “**Большая Советская Энциклопедия**”-д Чингисхан 1155 оны орчим төрөөд 1227 оны 8 дугаар сарын 25-нд нас эцэслэсэн гэсэний үндэслэл нь “**Татаро-монголы в Азии и Европе**” (“*Татар-монголчууд Ази Европ дахинаа*” Сборник статей, Москва, 1970), “**Жизнь Темучжина, думавшего покорить мир**” (“*Дэлхийг хөл доороо сөхрүүлэхийг санаархсан Тэмүүжиний амьдрал*” Н.Ц.Мункуев, Москва, 1973) энэ хоёрт байгаа боллолтой.

1155 он бол 3 дугаар жараны 9 дэх жил - “**Насан төгөлдөр**” хэмээх 8 цагаан мэнгэтэй харагчин Гахай жил юм. Нэгэнт манай эх сурвалжид болон дэлхийд алдартай английн их толь - “**Encyclopedia Britanica**”-д Чингис хаан 1162 онд төрсөн гэсэн нь таарч байгаагаар үндэслэн авч үзвэл

Чингис хаан маань 3 дугаар жараны 16 дахь жил - “Элдэв” хэмээх Нэг цагаан мэнгэтэй Цагаан Морь жил төрсөн нь тодорхой.

Зурхайн номд “Элдэв” хэмээх цагаан Морь жил: “Энэ жил төрсөн хүмүүн урьд хаан хүмүүн байж. Төрөө алдсан тул маш их сэтгэл зовсоныг тэнгэр мэдэж ноён хүмүүн болгож төрүүлсэн. ... Хаан хүмүүний ... заяатай. ... Гурван юм уу дөрвөн хүүхэдийн заяатай. Идээ, эд, эдэлбэр сайтай. Билэг оюун нь маш их, урлахуй ухаанд мэргэн. Бусадын гэмийг мэдэхдээ сайн ч түүнийг үл тоогч, шулуун шударга зантай. Бусадын эрхшээлд үл орогч.” гэхчлэн заасан байгаа их хааны байдалтай нэлээд таарч байгаа биз ээ.

Нэг цагаан мэнгэ: “Нэг цагаан мэнгэнд төрсөн хүмүүн төмөр махбодотой, тэнгэрийн хөвгүүний мэнгэтэй. Түүний шинж нь ариун бус хийгээд хэрүүл тэмцэлээс гэмтэх буй. Өсөх насанд зовох, өтлөхдөө жаргах болой. Юм байх ба үгүйг бодохгүйгээр наадам, найранд дуртай нэгэн. Эд малын хишиг нь бага. Эд эдлэл дунд зэрэгтэй явбал аминд сайн, их бол муу боловч ядуу үл явах тавилантай. Зарим жил эд агуурс, адгуус малын хишигийг олоход бэрх. Гарз ихтэй. Явдал нь их бүтээлч болой.

Сэтгэл нь цагаан, уур түргэнтэй боловч омог хилэн бага. Өглөгийн идээ болон архийг хүснэ. Үг нь олон, их зөрүүд, бодлогоиронгүй сэтгэлтэй. Гурван хүүтэй. Түүний билэг нь сүүжинд мэнгэ буй. Нүд хийгээд хамарын өвчинд өртөмтгий. Өвчин тусвал анагаахад бэрх. Үхэгсэдийн эд авбал гай болж, толгой эргэх, цээжний болон нүдний хий өвчин болох аюултай. Насны хэмжээ нь наян дөрөв.” гэхчилэн зурхайн бичлэгт дурдсаны зарим нь их хаантаны маань хувь тавилантай таарч байгаа байж болох юм.

Чингис хаан аргын тоололынхоор 5 дугаар сард (билэгийнхээр Могой сар) төрсөн байх гэсэн нотлогдоогүй таамаг сонссон боловч биеэр энэ тухайг ямар нэг эх сурвалжаас олж хараагүй яваа нэгэн. Энэ сарын зурлагад Могой сард төрсөн эр хүмүүн: “Ухаантай, арга мэх сайтай хүмүүнтэй зэрэгцэн оршиж үл чадмуй. Ивээн даагч бурхан сахиусандаа залбирч, сүм хийдээр явж эргэл мөргөл хийж байх чухал. 21, 37, 47, 57 настайдаа амгалан тайван аж амьдралтай байх болой.

30 настайдаа гал, уснаас сэрэмжилж байх хэрэгтэй.” гэж байгаагаас үзвэл их хаан маань Бурхан Халдун хайрхандаа мөргөн залбирсаар байсан, тэгээд бас Жамуха анд нь тэрслэн урвасан гэх мэтгэй нь дүйж байх шиг. Могой сарыг 4 дүгээр сарын 21-нээс 5 дугаар сарын 21 дуустал Үхэрийн ордон, 5 дугаар сарын 22-ноос 6 дугаар сарын 21 дуустал Хамтатгахын ордон тус тус ивээдэг аж.

Үхэрийн ордон-(4 дүгээр сарын 21-нээс 5 дугаар сарын 21)-д төрсөн хүмүүний хувь заяаны зурхайн бичлэгт заасаныг доор сийрүүлбэл:

“Зан төрх: Гайхамшигтай тэсвэр, тэвчээр, ажилч хичээнгүй зангийнхаа үрээр ялалт, амжилтанд хүрдэг. Маш шаргуу. Төлөвлөсөн ажилаа орхидоггүй. Бусадын зөвлөлгөөг бараг сонсдоггүй, заримдаа

зөвлөсөнөөс огт эсрэгээр ажиллах нь ч байдаг. Түүнийг барьц алдуулахад амаргүй, нэг уурлавал хэцүү. Гомдол хорсолоо мартдаггүй. Аливаад шударга байж чаддаг, хуучинсаг үзэлтэй, хардамтгай.

Давуу тал: Шийдэмгий, ажилсаг, аливаад бодолтой ханддаг, шулуун шударга, тууштай, эр зоригтой, үнэнч, тогтвортой, тайван, байгаагаараа байж чаддаг.

Дутагдал: Хувиа хичээгч, зөрүүд, зугаа цэнгэл болон тансаг байдалд дуртай, удаан, гэнэн хонгор.

Эхний арав хоногт төрөгсөд: Будын нөлөөгөөр оюуны чадамж ихтэй, математикт дур сонирхолтой. Хөдөө аж ахуй, худалдааны салбарт ажиллана. Үе үе амьдралын хүнд цохилт амсана.

Хоёрдахь арав хоногт төрөгсөд: Сарны нөлөөгөөр өгөөмөр, уран цэцэн яриатай, мөрөөдөмтгий, сайхан сэтгэлтэй, шийдмэг бус, улстөр болон утга зохиолд сонирхолтой, амьдралд нь азын тэнгэр ивээнэ.

Гуравдахь арав хоногт төрөгсөд: Санчирын нөлөөгөөр биеэ даасан, зөрүүд, гэвч өөрөөсөө илүү чадалтай хүмүүнд захирагддаг. Нийтэч бус, гутранги үзэлтэй. Ганцаардахаас болон ядуурахаас айдаг. 30-аас 35 нас хүртэлээ ядуувтар амьдралаар. Ухаалаг, тэвчээртэй байж чадвал амьдрал нь дээшилнэ.” гэж байх юмаа.

Нэгэнт л таамаглал дэвшүүлэх оролдлого хийж байгаа учираас дээрх Зан төрх, Давуу тал, Дутагдалтай тал гэсэнд дурдсан нь их эзэн хааны маань шинж төрх, үйл явдалтай нийцэж байгаа гэж төсөөлье л дөө. Чингис хаан 5 дугаар сард төрсөн гэвэл Үхэрийн ордны хоёрдахь юм уу гуравдахь арав хоногийн аль нэгэнд буюу 5 дугаар сарын 1-нээс 20-ны (5 дугаар сарын 21-нээс дараах үе нь Хамтатгахын ордонд хамаарах учир) хооронд мэндэлсэн байж таарнаа даа.

Энэхүү Үхэрийн ордны хоёрдахь ба гуравдахь арав хоногт төрсөн хүмүүний төөрөгийг дээр заасанаас уншиж үзээд Чингис хаан маань эл ордны хоёрдахь арав хоногт биш, гуравдахь арав хоногт мэндэлсэн байх гэж болмоор байгаа биз ээ. Яагаад гэвэл олон арван мянган цэрэгийн том жанжин хүмүүн бүх нууцаа нийтэд дэлгээд байдаггүй нь мэдээж учир “Нийтэч бус” байхаас өөрөөр яах билээ, тэрчилэн ялагдаж сүйрэхээс цаг ямагт сэрэмжлэх нь “Ганцаардаж, ядуурахаас айдаг” гэсэнтэй дүйнэ байх гэж үзье.

Харин “өөрөөсөө илүү чадалтай хүмүүнд захирагддаг” гэсэнийг Чингис хааны тухайнх болгож үзвэл олон арван мянганы олон зуун жанжинуудынхаа саналыг шүүн тунгааж үзээд оньчтойг нь “зөвшөөрч дагадаг”, өөрөөр хэлбэл, “олонхид захирагддаг” гэсэн санаа гэж үзэхэд болох мэт. Одоо төрсөн гарагийн төөрөгийг Үхэрийн ордны гуравдахь арав хоногийн буюу 5 дугаар сарын 11-нээс 20-ны хоорондын хоногоор авч үзье: Үхэрийн ордны III арав хоног буюу 5 дугаар сарын 11-нээс 20-ны өдөрүүдийн гараг ба тухайн гарагт төрсөн эр хүмүүний төөрөг:

Огноо	Гараг	Энэ гарагт төрсөн эр хүмүүний төөрөг
11/V-1162	Бямба	Нялхасын сүлд гараг. Өдөр тутамын үйл ажил барагдашгүй. Энэ гарагт төрөгсөд дүрс сайтай, буян хишиг нь өчүүхэн, эрүүл мэндийг нь сайтар хамгаалах шаардлагатай. Хөвгүүн төрсөн ахул дунд зэрэг.
12/V-1162	Ням	Эр хүмүүний сүлд гараг. Хувь хүмүүний зориг, идэвхтэй үйлийн эхлэл бөгөөд газар дээрх амьдралыг тэтгэгч бурханлиг гараг. Энэ гарагт төрсөн эр хүмүүн урт настай, асрахуй зөөлөн авирт болоод ард түмэндээ тустай үйлсийг хийгч.
13/V-1162	Даваа	Эхнэр хүмүүний сүлд гараг. Мөнхийн тэнүүлч. Ерөнхийдөө зүгээр гараг. Хүү төрвөл баян сайн, эд мал элбэг.
14/V-1162	Мягмар	Асур ороны сүлд гараг. Засаглалд дуртай, муу санаатай аж. Энэ гарагт төрсөн эр хүмүүн чирэгдэлд холбогдохоос болгоомжлууштай, нас охор, омог дээрэнгүй, амьдралд нь саад их, ажил үйлс нь зарим нэг талаар бүтэмж муутай.
15/V-1162	Лхагва	Ихэсийн болон хайр дурлалын гараг ажээ. Энэ гарагт төрсөн хөвгүүн эхдээ ширүүн, зан аашийн хувьд ширүүн ч амьдрал, эд агуурсын хувьд гачигдах нь бага байж болно.
16/V-1162	Пүрэв	Бөө, мэргэлэгчидийн бөгөөд аз жаргал авчрагч гараг. Энэ гарагт хөвгүүн төрвөөс царай муутай, оюун ухаан хурц, эрдэм номд сайн, номыг үйлдэгч мэргэн.
17/V-1162	Баасан	Түшмэдийн болон цэрэгийн албан хаагчидын сүлд гараг. Үүнийг завсарын гараг гэдэг. Энэ гарагт төрөгсөд бузарт бөгөөд дураараа аашлагч нэгэн. Хөвгүүн төрсөн ахул урт настай, авъяаслаг, гарын ур сайтай, баялаг хүмүүн.
18/V-1162	Бямба	Нялхасын сүлд гараг. Өдөр тутамын үйл ажил барагдашгүй. Энэ гарагт төрөгсөд дүрс сайтай, буян хишиг нь өчүүхэн, эрүүл мэндийг нь сайтар хамгаалах шаардлагатай. Хөвгүүн

19/V-1162	Ням	төрсөн ахул дунд зэрэг. Эр хүмүүний сүлд гараг. Хувь хүмүүний зориг, идэвхтэй үйлийн эхлэл бөгөөд газар дээрх амьдралыг тэтгэгч бурханлиг гараг. Энэ гарагт төрсөн эр хүмүүн урт настай, асрахуй зөөлөн авирт болоод ард түмэндээ тустай үйлсийг хийгч.
20/V-1162	Даваа	Эхнэр хүмүүний сүлд гараг. Мөнхийн тэнүүлч. Ерөнхийдөө зүгээр гараг. Хүү төрвөл баян сайн, эд мал элбэг.

Гараг бүрийн зурлагаас үзэхүл Чингис хаан маань Ням гарагт л төрсөн баймаар ажээ. Тэгвэл 1162 оны 5 дугаар сарын 11-нээс 20-ны хооронд Ням гараг хоёр удаа буюу 5 дугаар сарын 12 ба 19-нд байгаа. Нэг ордоноос нөгөө ордонд шилжих завсарын үед буюу хоёр ордон солилцогдох үед ойрхон төрсөн хүмүүнд тус хоёр ордны аль алиных нь нөлөө тусдаг гэж үздэг ажгуу. Тухайлбал, Үхэрийн ордон 5 дугаар сарын 21-нд дуусаад мөн сарын 22-нд Хамтатгахын ордон эхлэх хоорондын үед ойрхон, өөрөөр хэлбэл, 5 дугаар сарын 21-ноос арай өмнөхөн юм уу 21-нээс арай хойхно төрсөн хүмүүнд Үхэрийн ордон, Хамтатгахын ордон энэ хоёрын нөлөө хамт тусдаг ажээ.

Чингис хааны төрсөн өдөр гэж үзэж болох 5 дугаар сарын 12-ны өдөр нь Хамтатгахын ордны нөлөөнөөс 10 хоногоор алслагдсан Үхэрийн ордны III арав хоногийн эхний Ням гараг юм. **Хамтатгахын ордонд** төрсөн хүмүүний төөрөгийн зурлагыг доор (эхний 10 хоног буюу 5 дугаар сарын 21-нээс эхлэсэн 10 хоногоор) гаргасаныг Үхэрийн ордонд төрсөн хүмүүнийхтэй харьцуулан үзэх биз ээ:

“Хамтатгахын буюу Ихэрийн ордон-(V/22-VI/21)-д төрсөн хүмүүн: 5, 25 хоногт эс үхвээс 95 хүрнэ. Жал сар юм уу Бүс од, Лхагва гараг, 16-ны өдөрийн аль нэгэнд наран хөөрөхүй цагт мээнд үхнэ. Эд баялаг төгөлдөр, зөөлөн, архинд сүсэг ихтэй, үнэн өгүүлэгч, бусадын үгэнд мэргэн, найр хуриманд дуртай, тачаал ихтэн мөн.

Зан төрх: Хамагийн хувирамтгай хүмүүс. Оюуны чадвар сайтай, утга зохиолд авъяастай, аливааг амархан сурч мэддэг, дур булаам боловч хөнгөн хийсвэр зантай. Бусадыг байлдан дагуулахдаа сайн. Гэр бүлийн амьдралыг тээр шаадаг. Гадна төрхөндөө өөрөө өөртэйгөө зөрчилддөг байх гэж санамаар. Мөн чанартаа нэгэн хэвийн байдалыг тэрээр тэвчдэггүй.

Давуу тал: Оюуны чадавхи сайтай, аливаад авъяаслаг, түргэн сэтгэлгээтэй, хэд хэдэн ажилыг зэрэг хийх чадвартай, нийтэч, сэтгэгч.

Дутагдал: Хувиа хичээгч, тогтворгүй, дуулгаваргүй, найдваргүй, дэггүй, салан задгай, өөнтөгч, зальтай, уцаарламтгай, олон юмыг нэгэн зэрэг эхлэсэн мөртлөө дуусгадаггүй, хуурч мэхлэх хандлагатай, чалчаа.

Эхний арав хоногт төрөгсөд: Бархасбадын нөлөөгөөр ухаалаг, зөн билэгтэй, урлагт дур сонирхолтой, элдэв шуналгүй, нэр алдар мөнгө хөрөнгөгүй бол шашины эргэцүүлэлээр сэтгэлээ хангадаг, амьдрал нь бэрхшээл, тэмцэлээр дүүрэн, бусадын гарт хорлогдох магадлалтай” гэжээ.

Хүмүүний төрсөн цагийн төөрөг дэх 12 зурлагаас харвал их хаан маань Хонь цагт төрсөн байж болмоор аж. Энэ цагт төрсөн хүмүүний төөрөгийн зурлагыг сийрүүлбэл: **“Хонь цаг-(Өвөл: 13.40-15.40; Зун: 14.40-16.40)-т төрсөн хүмүүн** буян хишигтэй, баян сайн. Эд хогшил ихтэй аж төрөх төөрөгтэй. Хүүхэд олон, нас урт. Ааш сайн, ёс төрийг мэдэх. **Урлах эрдэм, дайсанаа номхотгон дарах үйлд мэргэн чадалтай. Бусадтай зоригтой харьцаж чаддаг. Бусадын дэмжлэгийг авна. Ингэснээр амжилт олно.** Буяны үйлд сайн. Харин эцэг эхтэйгээ хөндий явах. Төрсөнөөс хойш 10 хоног, 3 сар, 9 жилд эс эндвээс 55-аас 64 хүрнэ.” гэж байгаа.

Хүмүүний төрсөн өдөр нь сарны тоололын хэдэнд байж вэ гэдэгийг энгийн оноолтоор шууд гаргах боломжгүй. Шинийн нэгнийхээс эхлээд битүүний өдөр хүртэлх хоногийн тоо нь сар бүр адилгүй, тухайлбал, зарим өдөр хоёр дахин давтагдах, зарим нь тасрах, хоёр жил дараалан 354 орчим хоногтой, гурав дахь жил бүр нь илүү сартай буюу 384 орчим хоногтой жил байх зэргээр нэг жилийн дотор 29 хоногтой сар олон, 30 хоногтой сар цөөн байдаг байна. Иймээс зөвхөн эфемеридийн хүрд ашиглаж байж тухайн жилийн өдөрийн сарыг, тэрчилэн гараг ододын байрлалыг нарийвчлан тодорхойлдог байна. Энэхүү эфемеридийн хүрдэнд огторгуйн од гараг тухайн жилийн тухайлсан өдөрт хаана байрлаж байхыг болон нар сарны хиртэлт, ододын цацрагийн хувьсалт гэхчлэнгийн одот тэнгэрийн үзэгдэлийн зүй тогтолыг нарийвчлан тооцоолсон байдаг аж.

Чингис хааны төрсөн өдөр тэргэл сартай байж гэлцдэг. Тэргэл сар гэдэг бол арван тавны өдөрийн дүүрэн сар. Тэргэл сар нь манай дэлхийн байгаль ба хүмүүн болон амьтадад ихээхэн хүчтэй нөлөө бүхүй байдаг аж. **“Тоон өдөрийн төөрөг”** хэмээх зурлагын 6 төрөл бичлэгээс тунгаан үзвэл их хааны төрсөн өдөрт хамагийн ихээр хамаарч болох нь арван тавны сартай өдөр мөн мэт санагдана. Үүнийг доор сийрүүлэв:

“Шинийн 3, 9 ба 15, 21, 27-ны өдөр төрсөн хүмүүн: Аж амьдрал нь аз жаргалаар дүүрэн. Төрийн албан хаиваас ихээхэн дэвшиж болох ажгуу. Эцэг эхдээ түшигтэй. Намуун зөөлөн зантай. Хүмүүстэй амархан нийцдэг бөгөөд хэн нэгэн гомдоосон ч түүнийг амархан мартана. Ёс төрийг мэддэг, урт настай. Эд агуурс дээр жаргах.” гэсэн байна.

Хүмүүний хувь заяаг бас төрсөн жилийг нь **“Сүмд буулгахуй”** буюу **“Бурхан багшийн биед байрлуулахуй”** аргаар тордорхойлдог аж. Чингис хаан маань Морь жилийн зун мэндлэсэн тул дээрх оноолт ёсоор

Бурхан багшийн чихнээ төржээ. **“Бурхан багшийн чихэнд зуны улиралд төрсөн хүмүүн: Цэцэн мэргэн, тор ёсыг таалагч, хишиг буян ихтэй нэгэн болмуй”** гэсэн байна.

Хүмүүний зан төрх, ажил үйлс, бүтээл зүтгэл, аж амьдралыг нь сайн мэддэг ахул тухайн хүмүүний төөрөгийг зурхайн зурлагад заасан бичлэгтэй нь дүйцүүлж үзсэнээр эрт, эдүгээ, ирээдүй хойчийнхоор нь тодорхойлж болдог гэсэнээр үндэслэн ийнхүү 850 шахам жилийн тэртээд мэндлэсэн их хааныхаа талаар монгол бидэнд уламжлагдан ирсэн өөдрөг гэгээн төсөөлөлд хөтлөгдөн төрсөн өдөрийг нь тогтоох хэмээн оролдсон минь энэ болой.

Ингээд энэ дэлхийн гарамгай жанжин, төрийн зүтгэлтэн, найман зууны тэртээд Их Монгол улсын тулгар төрийг байгуулсан, энэ дэлхийн талыг байлдан дагуулж, хүмүүн төрөлхтөнийг ихэд ухааруулсан, өмнөх мянганы аугаа их хүмүүн, монгол түмэн бидний их өвөг бөгөөд монголын үндэсний бахархал **Чингис хаан маань монгол зурхайн тоололын 3 дугаар жараны 16 дахь жил – “Элдэв” хэмээх Нэг цагаан мэнгэтэй, Цагаан Морь жилийн Зун, 1162 оны 5 дугаар (Могой) сарын 12-нд буюу Үхэрийн ордоны эрхшээлийн гуравдахь 10 хоногийн эхний Ням гараг, Гурван хөх мэнгэтэй, Мод суудалтай, Тэргэл сартай, Цагаан Нохой өдөрийн Хонь (14.40-өөс 16.40-ийн хооронд) цагт Бурхан багшийн чихнээ мэндлэжээ** гэсэн таамаглал дэвшүүлж болох юм шиг байна.

Их хааны төрсөн өдөр, цаг мэт нарийн ширийнийг хэн нэгэн мэргэд аль хэдийнээ тогтоочихсон байгаа байх хэмээн бодовч орчин үед өргөн дэлгэр болсон зурхайн ном хэвлэлээс уншаад, бас төрсөн ах Л.Цэрэндоржийнхоо зурхайн зурлагын нэлээд цуглуулгаас үзээд ийн “зориглосон” минь энээ.

Дашрамд өгүүлэхүйд ах Цэрэндорж маань тэртээ цагийн хөдөө орон нутагт бага сургууль байтугай, “тэнхим” гэдэг нь ч ор сураггүй байсан үед өсөх насаа мал дагасаар “гадаа гандаж, хөдөө хөхөрч” өнгөрөөж ном, соёлд суралцах ямар ч боломжгүй байсан харанхуй үеийг туулсан боловч хожим нь монгол бичиг, кирил бичгийг өөрөө оролдож сурсан, орос хэлээр ч бага сага яриад байдаг болсон, ерөөл магтаалыг зохиогоод хэлчихдэг, ерөөс аливаа юманд авхаалжтай, ухаалаг сэргэлэн, хөдөлмөрч хичээнгүй хүмүүн байсан бөгөөд амьдралынхаа сүүлийн жилүүдэд буюу 90-ээд оноос хойш зурхайн ухааныг ихэд сонирхож ирсэн нэгэн. Ах минь даанч эрт үед, “монгол орон хөмрөөстэй тогооноосоо гарч ядаж байх үед” буюу “хөдөөд боловсрол хөгжүүлэх ажил эрч хүчээ авч төдийлөн чадаагүй байсан” үед төрсөн нь халаглам билээ.

Зарим юмны зурлагыг ах маань гаргачихаад “юм хэлээд байдаг болсон” хүмүүн байгаа. Тухайлбал, 2004 оны сонгууль болж өнгөрсөн сар, өдөрийн зурлагыг хожим нь гаргаж үзээд “үр дагавар нь муухан л болох

юм байна” гэж байсан нь одоо үед зарим талаар “нотлогдоод” ч байх шиг. Иймээс төр, нийгмийн аливаа зангаргатай том үйл явдлыг болдогсон бол “Сарын сайныг Саатан хүлээж, Өдөрийн сайныг Өнжин хүлээж ...” гэдгийн дагуу төв түвшин, хожимын үр дагавар нь эерэг байхуйц сар, өдөр, цагийн нөлөө, од эрхэсийн байршил эдгээрийн аль зохистойг харгалзан шилж тогтоосноор юм уу тогтоолгосноор эхлэн хэрэгжүүлдэг байваас буруугүй мэт санагдана. Ерөөс анхны том үйлийг сайн цаг мөчид эхлэсэн ахул тэр том үйл явдлын мөрөөр дагалдан гарах олон үйл явцын хувь заяа нь ч гэсэн “мордохын хазгай” гээч болохооргүй тавилантай байдаг хэмээх ажгуу.

Их хааныхаа төрсөн өдөрийг ах маань эсэн мэнд ахуйдаа тогтоох гэж санаагүй байх л даа хөөрхий, тэр үед надад ч гэсэн энэ тухайд ухаан сэхээ орж ахдаа хэлэх сөгөө байсангүй л дээ. Ах маань үүнийг анзаарч оролдсон бол Чингис хааныхаа мэндлэсэн цаг үеийг мадаггүй тодруулахуйц зурлагыг үндэслэлтэйгээр гаргах байсан байх даа.

Одоо яая гэх вэ, бичвээр ийм л таамаглал дэвшүүлвэй.

Ухаант олон мэргэд минь болгоон соёрхож алдаа оноог нь тунгаах биз ээ.

Жич: Эл өгүүллийг “Өнөөдөр”, “Уртраг-Өргөрөг”, “Дал”, сонин нийтэлсэн бөгөөд “Өнөөдөр” сониньхон интернетэд оруулан тив дэлхийд тархсан Монгол олон нийтэд хэлэлцүүлсэнд гүнээ талархнам.